



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/61

Эрдэнэт

### ┌ Дархлаажуулалтыг зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6а, 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь хэсэг, Гамшгаас хасгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.11, 32.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, Дархлаажуулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.2, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 9 дүгээр зүйлийн 9.17 дахь заалт, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 05 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/33 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг дархлаажуулах үйл ажиллагааг дэмжих Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Зохион байгуулах техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын чиглэлийг хоёрдугаар, Коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааны нэгдсэн удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Коронавируст халдварын эсрэг вакциныг татан авах, хүн амыг аюулгүй дархлаажуулах үйл ажиллагааг мэргэжил аргазүй, удирдлага зохицуулалтаар хангах дархлаажуулалтын нэгдсэн удирдамжийн хэрэгжүүлэх, төрийн байгууллага, аж, ахуйн нэгж, албан байгууллагыг татан оролцуулж, үйл ажиллагааг нь уялдуулан зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Онцгой байдлыг газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Г.Жигдэнгомбо), Тагнуулын газар (М.Очирбат), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга, аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргалд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2021 оны ...  
02 дугаар дугаар сарын 16-ны өдрийн  
1161...дугаар захирамжийн 1 хавсралт

**ДАРХЛААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн дарга: А.Түвшинжаргал-Аймгийн Засаг даргын орлогч
- Гишүүд
- Н.Бямбацэцэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
  - М.Мөнхбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
  - А.Бумансор-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
  - С.Цэрэнсамбуу-Цагдаагийн газрын дарга
  - Г.Ганбаатар-Онцгой байдлын газрын дарга
  - М.Очирбат-Тагнуулын ерөнхий газрын Орхон аймаг дахь газрын дарга
  - Г.Жигдэнгомбо-Мэргэжлийн хяналтын газрын дарга
  - О.Ариунгэрэлт-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
  - Б.Баасансүрэн-Баян-Өндөр сумын Засаг дарга
  - Б.Зоригтбаяр-Жаргалант сумын Засаг дарга
  - Т.Батмөнх-"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын нэгдүгээр орлогч бөгөөд ерөнхий инженер
  - Ц.Мөнхцэцэг-Аймгийн Засаг даргын зөвлөх
- Нарийн бичгийн дарга: О.Батцэнгэл-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

\_00\_



Аймгийн Засаг даргын 2021 оны ...  
02 дугаар дугаар сарын 16 ны өдрийн  
1/61...дугаар захирамжийн II хавсралт

**ДАРХЛААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ТЕХНИКИЙН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН,  
АЖЛЫН ЧИГЛЭЛ**

№	Нэр	Албан тушаал	Ажлын хэсэг
1	Дарга А.Баярхүү 99368309	НЭМТ-ийн дарга	Дархлаажуулах үйл ажиллагааны ерөнхий удирдлагаар хангаж, аюулгүй дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах
3	Дэд хурандаа Д.Золжаргал 99555152	Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга	дархлаажуулалтын явцад болзошгүй эрсдлээс сэргийлэх, аюулгүй байдлыг хангах бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах
4	Дэд хурандаа Б.Эрдэнэхүү 99196664	Цагдаагийн газрын Нийтийн хэв журмын тасгийн дарга	Вакциныг тээвэрлэх, хүлээн авах, шуурхай түгээх, хадгалах, дархлаажуулах үйл ажиллагааны үеэр дархлаажуулалтын цэгүүд, ЭМБ-ын ажилтнуудын аюулгүй байдлыг хангах. Хууль бус жагсаал цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох арга хэмжээг авах.
5	Ахлах дэслэгч О.Нацагдорж 99135831	Тагнуулын газрын ажилтан	Дархлаажуулалтын үйл ажиллагааны аюулгүй байдалд мэдээллийн дэмжлэг үзүүлж, салбар хооронд хамтран ажиллах.
	Л.Галсансайнхувьт 99368164	АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн	Вакцин, дагалдах хэрэгслийг татан авах, тээвэрлэх, дархлаажуулах үйл ажиллагааны зардал, нөөц бүрдүүлэлтийг тооцох, хяналт тавих, тайлагнах
6	Д.Жаргал 99357868	МХГ-ын Халдварын сэргийлэлт, хяналтын улсын ахлах байцаагч	Вакцины төлөвлөлт, нийлүүлэлт, вакцины чанар, аюулгүй байдал, тээвэрлэлт, хадгалалт, дархлаажуулалтын явцад хяналт хийж салбар хооронд хамтран ажиллах
7	Ж.Энхсайхан 99058130	Баян-Өндөр сумын Засаг даргын орлогч	Дархлаажуулах түр цэгүүдийн нөхцлийг хангахад зохион байгуулалтын арга хэмжээ авах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, цаг үеийн нөхцөл байдлыг хэлэлцэн, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна
8	Б.Учрал 99955000	Жаргалант сумын Засаг даргын орлогч	
2	Б.Одонтунгалаг 99057151	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга	Мэргэжил арга зүйгээр хангах, ДДУХ-ын үеийн эмнэлгийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах
9	Ж.Ганчимэг 99351003	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Эрдэнэт клиникийн ерөнхий эмч	Стратегийн ач холбогдолтой үйлдвэрийн ажилчдыг дархлаажуулалт үйл ажиллагааг хэрэгжүүлэх

10	Б.Жаргалсайхан 99356267	Өрхийн анагаах ухааны Орхон аймаг дахь салбар зөвлөлийн дарга, Мөнхсүндэрл ӨЭМТ- ийн дарга	Дархлаажуулах байнгын болон түр цэгүүдэд ажиллах бэлэн байдлыг хангах, хүн амын дархлаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх
11	Нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин 99553198	ЭМГ-ын Дархлаажуулалт хариуцсан ажилтан	Дархлаажуулах үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр ханган зохион байгуулах, төлөвлөгөөний хэрэгжилт, дархлаажуулалтын хамралтын мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч, уялдааг хангах

\_00\_

Аймгийн Засаг даргын 2021 оны ....  
02 дугаар дугаар сарын 16 ны өдрийн  
16/02 дугаар захирамжийн III хавсралт

## КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН УДИРДАМЖ

**Зорилго:** Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх, цар тахлыг хохирол багатай даван туулахад оршино.

### **Зорилт:**

1. Вакцин, дагалдах хэрэгслийг татан авах, түгээх, хадгалах, дархлаажуулах цэгүүдэд аюулгүй хүргэх

2. Коронавируст халдварт өртөж болзошгүй зорилтот бүлгийн хүн амыг тодорхойлж, богино хугацаанд аюулгүй дархлаажуулах

### **Бэлтгэл ажлын хүрээнд:**

1. Дархлаажуулах цэгүүдийн бэлэн байдал, аюулгүй байдлыг хангах /Байнгын, Түр, Явуулын/

2. Дархлаажуулалтын цахим бүртгэлийн бэлэн байдлыг хангах /Компьютр, интернет, хурууны хээ уншигч/

3. Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн бэлэн байдал

4. Хүний нөөцийн төлөвлөлт ба сургалт, аюулгүй байдал

5. Зорилтот бүлгийн нарийвчилсан судалгаа

6. Дархлаажуулалтын зураглал /газарзүйн зураглал, хүйтэн хэлхээний чадавхи, хүний нөөц, байнгын, түр цэгийн байршил, зай, зорилтот бүлэг, хүрч үйлчлэхэд бэрхшээлтэй газар зэрэг үндсэн мэдээллийг багтаасан/ гаргаж төлөвлөлт хийх.

7. Байгууллага бүр бичил төлөвлөгөө

8. Вакцинжуулах үйл ажиллагааны явцад гарч болох эрсдлийг үнэлэх, хариу арга хэмжээг төлөвлөх

9. Үйл ажиллагааны зардал, санхүүжилт

## ДАРХЛААЖУУЛАЛТАД ЭХНИЙ ЭЭЛЖИНД ХАМРАГДАХ ХҮН АМЫН СУДАЛГАА

№	Зорилтот бүлэг	Хүн амын тоо	
1	Эрүүл мэндийн байгууллагын ажилтан	1613	
2	Хариу арга хэмжээнд ажиллаж байгаа Онцгой байдал, Цагдаа, Тагнуул, Мэргэжлийн хяналт, Гаалийн ажилтан	Онцгой байдлын ажилтан	206
		Цагдаагийн байгууллагын ажилтан	456
		Тагнуулын байгууллагын ажилтан	17
		Мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтан	42



		Гаалийн байгууллагын ажилтан	24
3	Эрсдлээс сэргийлэх зорилтот бүлэг	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан	1749
		СӨБ-ийн багш, ажилтан	1114
		Их, дээд сургуулийн багш, ажилтан	150
		Коллеж, МСҮТ-ийн багш, ажилтан	136
4	Стратегийн ач холбогдол бүхий байгууллагын ажиллагсад	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажиллагсад	6692
		Эрдэнэт үйлдвэрийн гэрээт компани	230
		Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын ажиллагсад	446
		Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн ажиллагсад	226
		Эрдэнэт Ус, дулаан түгээх ОНӨХК-ийн ажиллагсад	325
5	Эрсдэлт бүлэг	Архаг хууч өвчтөй, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, дархлаа дарангуйлах эм ууж байгаа, орон гэргүй иргэд	11184
Нийт			24678

Дараагийн ээлжинд вакцины хангамж, хүртээмж, өвчлөлийн тархвар зүйн байдлаас хамаарч хүн амыг эрэмбэлж, үе шаттай хамруулна.

**Хэрэгжүүлэх байгууллага:** Эрүүл мэндийн газар

Вакциныг шуурхай татан авах, түгээх, дархлаажуулах бичил төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, дархлаажуулах цэгүүдийн бэлэн байдлыг хангаж, хүн амыг аюулгүй дархлаажуулах удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж, мэдээ, тайланг нэгтгэн мэдээлнэ. Эрүүл мэндийн ажилтны ажлын ачаалал, алдаа эрсдлийг багасгах арга хэмжээ авна.

**Хамтран ажиллах байгууллагууд:**

- Аймгийн Засаг даргын Тамгын газар
- Онцгой байдлын газар
- Цагдаагийн газар
- Тагнуулын Ерөнхий газрын Орхон аймаг дахь газар
- Мэргэжлийн хяналтын газар
- Боловсрол, соёл, урлагийн газар
- Баян-Өндөр сумын ЗДТГ
- Жаргалант сумын ЗДТГ
- Улаан загалмайн хороо

**Шуурхай штаб:** Орон нутагт Ковид-19 халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг удирдлагаар хангах, дархлаажуулалтын цэг тус бүрт ажиллах хамтарсан баг

ажилтан/-ийг томилж, үүрэгжүүлэх. Дархлаажуулах үйл ажиллагааны зардал /хөргөгч, тоног төхөөрөмж, тээврийн, томилголт, хоол, илүү цагийн хөлс, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, харилцаа холбоо/, дархлаажуулалтын цахим бүртгэлийн бэлэн байдал /компьютр, интернет, хурууны хээ уншигч/ зэргийг тухай бүр шийдвэрлэнэ. Төлөвлөгөөний хэрэгжилт, дархлаажуулалтын хамралтын мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч хяналт тавина.

**Онцгой байдлын газар:** Вакцин, дагалдах хэрэгслийг татан авах, тээвэрлэх, түгээх, дархлаажуулах явцад болзошгүй эрсдэл учирсан тохиолдолд асуудлыг шуурхай шийдвэрлэнэ.

**Цагдаагийн газар:** Вакциныг тээвэрлэх, хүлээн авах, шуурхай түгээх, хадгалах, дархлаажуулах үйл ажиллагааны үеэр дархлаажуулалтын цэгүүд, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын аюулгүй байдлыг хангана.

Тагнуулын газар: Дархлаажуулалтын үйл ажиллагааны аюулгүй байдалд мэдээллийн дэмжлэг үзүүлж, салбар хооронд хамтран ажиллах. Хууль бус жагсаал цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох арга хэмжээг цагдаагийн байгууллагатай хамтран авч хэрэгжүүлнэ.

**Мэргэжлийн хяналтын газар:** Вакцины төлөвлөлт, нийлүүлэлт, вакцины чанар, аюулгүй байдал, тээвэрлэлт, хадгалалт, дархлаажуулалтын явцад хяналт хийж салбар хооронд хамтран ажиллана.

**Баян-Өндөр, Жаргалант сум:** Дархлаажуулах түр цэгүүдийн нөхцлийг хангахад зохион байгуулалтын арга хэмжээ авах, иргэний нийгмийн байгууллага, сайн дурын идэвхтний оролцоог хангах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, цаг үеийн нөхцөл байдлыг хэлэлцэн, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

**Хэвлэл мэдээллийн алба:** Дархлаажуулалтын талаарх үнэн зөв мэдээллийг баталгаат эх сурвалжаас авч олон нийтийн мэдээллийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх, вакцинд итгэх олон нийтийн итгэлийг бий болгох, ухуулга, мэдээлэл, сурталчилгааг үнэ төлбөргүй, шуурхай түгээх.